



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/310

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн
ангийн дарга нарт сургалт зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2.5, 13.3.1, 13.3.2 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн удирдлага төлөвлөлтийн баримт бичгийг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 26-аас 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулсугай.


2. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулж хавсралтаар баталсугай.

3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдад гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлалыг таниулах, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Эрдэнэбат)-д даалгасугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2025

231010946

05
А/Б/10
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 26-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд дүн
1	Цайны зардал /3 өдөр/	25*3	3,666	275,000
2	Тамгын газрын дарга нарын хоол	23 (3 өдөр, өдрийн хоол)	35.000	2.415.000
3	Буудлын зардал (сургалт зохион байгуулах 3 өдөр)	3*3 (3 өдөр)	140.000	1.260.000
4	Сургалт зохион байгуулах хүний хоол	5 хүн 3 өдөр /Өдөр, орой/	35.000	1.050.000
Нийт				5,000,000